

“ХҮНИЙ НҮДТЭЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ АРДЫН ОНЬСОГО”

Ц.Цогзолмаа<sup>1</sup>

**Товч агуулга:** Монгол ардын оньсогыг хэлшинжлэлийн үүднээс судалж аливаа *оньсогыг* зохиоход юуг үндэслэж юутай адилтгаж илэрхийлж байгааг тодорхойлоход оршино.

**Түлхүүр үг:** оньсого, хүн, нүд, мэдэрхүй, адилтгал, далд зүйрлэл, танихүйн хэлшинжлэл

Бидний судалгааны санд буй хүний амьдрал, ахуйн тухайт монгол ардын оньсого нь маш олон төрөл зүйлд хувааж болохуйц өргөн дэлгэр бөгөөд тэдгээрээс зөвхөн *хүн*, түүнтэй холбоотой оньсогыг авч үзэхэд нийт 1420 оньсого байна. Энэхүү илтгэлд зөвхөн “*хүний нүд*”-тэй холбоотой *оньсогын* жишээгээр монголчууд *оньсого* зохиохдоо чухам юунд хандаж, юутай зүйрлэж, сэтгэхүйн ямар үйлдэл хийдэг зэрэг онцлогийг гаргахыг зорьсон болно. Ингээд бидний судалгааны санд “*хүний нүд*”-тэй холбоотой 103 оньсого байгаад ажиглалт хийе.

Үүний тулд бид нэгдүгээрт, тайлбар толь бичиг болон нэвтэрхий толь бичгээс нүдийг хэрхэн тодорхойлсонтой танилцаж нүд ямар шинжтэй, үүрэгтэй ямар эрхтэн болохыг нь тодорхойлох, хоёрдугаарт, монголчууд нүдийг эдгээр оньсогод юутай хамаатуулж үздэг, нүдэнд хэрхэн ханддаг, ямар шинжийг анхаарч чухалчилж үздэг байдалд үндэслэн ангилал хийхийг зорьсон юм.

Монгол ардын оньсого судалсан байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд оньсого нь хэлшинжлэлийн бусад судлахуунтай харьцуулахад бага судлагдсан, тэр тусмаа хэлний үзэгдэл болохын хувьд цааш судлах өргөн талбар бүхий судалгааны сонирхолтой хэрэглэгдэхүүн болно.

Оньсогыг зөвхөн ардын аман зохиолын нэгэн төрөл зүйл болох талаас судлаад зогсохгүй хэлшинжлэлийн үүднээс, тэр дундаа ард түмний танин мэдэхүйн үйл ажиллагаа, сэтгэн бодох үйл явц, үндэсний сэтгэлгээний онцлогтой холбон соёлын хэл шинжлэлийн үүднээс судлах нь монгол хэлшинжлэлд хувь нэмэр оруулна. Ард түмний амьдралын товч хураангуй болсон оньсогын жишээгээр ерөнхий хэлшинжлэлд шинэ хандлага болох танин мэдэхүйн хэлшинжлэл, соёлын хэлшинжлэлийн онол, судалгааны хүрээг баяжуулах боломжтой.

*Оньсого* гэдэг нь юу вэ? Бид энэ асуултад дараах байдлаар хариулж байгаа юм. “*Оньсого гэгч, юуны өмнө ардын аман зохиолын яруу найргийн товч хураангуй бүтээлийн төрөл зүйлийн нэг бөгөөд бүхэлдээ хүний ухаан билгийг шалгаж, бодох сэтгэх чадлыг нь хөгжүүлэхэд чиглэгдсэн, тухайн үндэстэн ард түмний танин мэдэх сэтгэлгээний түүхт хөгжлийн үр дүнг тусгасан гүн, дэлгэр агуулгатай, гайхам уран яруу ёгт хэлбэртэй асуудалт асуулт мөн гэж*

1. Монгол Улсын Их Сургууль

болно".<sup>2</sup>

Нүдний тухай оньсогын талаар ярихаас өмнө *Нүд* гэдэг нь чухам ямар эрхтэн, ямар шинж, үүрэгтэйг тодорхойлох хэрэгтэй. Нүдний тухай мэдлэг нь нүдний тухай оньсого зохиох, таах танихуйн шинж болно. Нөгөө талаас нүдний тухай оньсого зохиохдоо монголчууд чухам юунд хандаж байгаа нь бас л монголчуудын амьдрал ахуй, ертөнцийг таньсан байдлын тусгал болох юм.

*Нүд* хүний 5 мэдэрхүйгийн нэг. Хүн хүрээлэн буй орчноо танин мэдэх биологийн үндэс нь мэдрэхүйн эрхтэний бүтэц, үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Хүн *харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүрэлцэх* хэмээх таван мэдрэхүйгээрээ юмс үзэгдлийг танин мэдэж, орчиндоо идэвхтэй зохицож, амьдрах боломжоо нэмэгдүүлж байдаг.

Нүд – хүний хамгийн чухал эрхтэний нэг. Харааны мэдрэхүйн тусламжтайгаар бид хүрээлэн байгаа орчиндоо орон зайн баримжааг олж авч байдаг. Биднийг хүрээлэн байгаа бодит ертөнцийн бүх юм, үзэгдэл тодорхой орон зайд оршин тогтнож байдаг. Орон зайн хүртэхүй бол бидэнд юмсын хэлбэр, дүрс, хэмжээ, багтаамж, хоорондын зай, харьцаа биднээс алсалж буй хол ойрын зай зэргийг танин мэдэхэд тусалдаг. Юмны багтаамжийг тусган хүртэхэд хоёр нүдний зэрэглэсэн хараа ихээхэн үүрэгтэй. Юмыг хоёр нүдээр харахад нүд тус бүрийн торлог бүрхэвчид уг зүйлийн хоёр дүрс бууж тусгагддаг. Гадаад орчинтой харьцаж байгаа мэдээллийн 80-90 хувийг нүд өгдөг. Эндээс хэр чухал эрхтэн гэдэг нь харагдаж байна.

Ингээд нүдний бүтэц, шинж, үүргийг толь бичиг хэрхэн тодорхойлсонтой ганилъя.

Малый академический словарь. <http://dic.academic.ru/>

### Нүд Глаз

Нүд Глаз *-а (-ү), предл. о глазе, в глазу, мн. глаза, глаз, -айн, -и.*

1. Харах эрхтэн. Орган зрения. *Анатомия глаза. Близорукие глаза. Голубые глаза. Зажмурить глаза. Прищурить глаза. Вытаращить глаза.*

*У него был немного вздернутый нос, зубы ослепительной белизны и карие глаза.* Лермонтов, Максим Максимыч.

*Снег так ослеплял, что глаза стали слезиться.* Закруткин, Кавказские записки.

||

*Харц Взгляд, взор. Встретиться глазами. Потупить глаза. Окинуть глазами.*

*Мы все были влюблены в Солечку и, стоя на лестнице, провожали ее глазами.* Л. Толстой, Детство.

*Все танцующие остановились и с любопытством устремили глаза на новую пару.* Куприн, Молох.

2.

Харах чадвар Способность видеть: хараа зрение. *Мартышка к старости слаба глазами стала.* И. Крылов, Мартышка и Очки.

*[Дочь] работала, работала, — Да и шишлась глаз.* И. Никитин, Уличная встреча.

*только ед. ч., какой и кого.* Онцгой харах чадвар Особая способность ви деня: ямарваа нэг ажил, мэргэжлийн ачаар хүнд бий болсон харах чадвар способность ви деня, присущая человеку благодаря тому или иному занятию, профессии и т. п. *Опытный глаз. Наметанный глаз.*

2. Гаадамба Ш., Цэрэнсодном Д. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. УХГ. УБ. 1978. х.

Ц.Цогзолмаа

*Кавалерийский глаз Ростова не мог не заметить, что Наполеон дурно и не твердо сидел на лошади.* Л. Толстой, Война и мир.

*Человек, не имеющий хорошего морского глаза, не может хорошо управиться со своим кораблем.* С. Макаров. Рассуждения по вопросам морской тактики.

*Одарка глазом знатока осмотрела сапог. — Лгать его мой мужик не будет.* Н. Островский. Как закалялась сталь.

||перен.: только ед. ч. разг. Хараа хяналт, харгалзах Надзор, присмотр.

У семи нянек дитя без глазу. Пословица.

[Курслепов:] *Все твоё несмотрение. Везде свой глаз нужен. У меня две тысячи рублей пропало.* А. Островский. Горячее сердце.

— *В детских учреждениях, в общежитиях и столовых не достаёт женского глаза и заботы.* Ажаев, Далеко от Москвы.

3. *только ед. ч. разг. устар. Нүдний хор гэсэн үг* То же, что *дурной глаз.*

*Мать задавала себе и няньке задачу: выводит здоровенького ребенка, беречь его от простуды, от глаза и других враждебных обстоятельств.* И. Гончаров. Обломов.

— [Мужики] *верят в глаз, и в порчу, и в привороты.* Л. Толстой. Анна Каренина.

**Монгол хэлний дэлгэрэнгүй гайлбар толь бичигт** нүдийг дараах байдлаар тодорхойлсон байна.

• **Нүд /эн/ 1.** Хүн, амьтны харах эрхтэн: цэцгий, аньсага, нулимсны булчирхай зэргээс бүрдэнэ: нүдний аяга /нүдний ухархай/, нүдний давхраа /зовхины доод ирмэгт уртааш тогтсон гүн нугалаас/, нүдний уг /хүүхэн харааны чанх эсрэг тал дахь нүдний дотор талын хэсэг/, нүдний үүл /нүдэнд үүссэн цагаан толбо/, нүдний ухархаа /нүдний аяга/, нүдний тар /зовхины ирмэг/, нүдний цагаа /нүдний үүл/, нүдний цэцгий /нүдний хүүхэн хараа/, хар нүд /нүдний цэцгийн гаднах дугариг/ гэх мэт. 2. Сараалжлан дөрвөлжилсөн хэсэг буюу нэг нүх

• 3. Юмны цоохор толбо

4. Хоёрын тооны ёгт нэр. (М-С. Ред. Л.Болд. УБ. ШУА. 2008. х. 1412-1414)

**Монголын нэвтэрхий толь. МУШУА. УБ. 2000. х.647**

Нүд /лат. oculus/ нугалмайтан, нугалмайгүйтэн олон амьтны харах эрхтэн. Амьтан бүхний нүд харилцан адилгүй. Хүн, нугалмайтан хос нүдтэй. Нүдний алим /тархитай харааны мэдрэлээр харааны төвд холбодог/, туслах эрхтэнээс /нүдний хөдөлгөх булчин, аньсага, нулимсны булчирхай/ бүрддэг. Хүүхэн хараагаар /солонгон бүрхэвчийн нүх/ гэрэл орж нүдний цэцгийг хугарч харах хөлтөн голдуу хос нүдэнцэртэй байдаг.

**Зөвлөлтийн нэвтэрхий толь бичигт** нүдийг дараах байдлаар тодорхойлсон байсан.

Нүд, хүн, нугалтайтан, нугалмайгүйтэн олон амьтны харах эрхтэн. Хүн, нугалтайман амьтдын хос эрхтэн. Нүд /нүдний алим/, тархитай харааны мэдрэлээр харааны төвд холбогддог мөн туслах эрхтэнээс /нүдний хөдөлгөх булчин, аньсага, нулимсны булчирхай/ бүрддэг. Хүүхэн хараагаар /солонгон бүрхэвчийн хүн/ гэрэл орж нүдний алим, эвэрхий бүрхүүл, болор, шиллэг биед хугарч, харж буй юмсын дүрсийг торлог бүрхүүл дээр тусгадаг. (М., 1985 г. стр. 310, Орч.Ц.Цогзолмаа)

**Большая советская энциклопедия-** д нүдний үүрэг, өнгийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Нүдний харах чадамжинд дараах хэсэг үүргийг хэлж болно. Үүнд: гэрэл мэдрэх, өнгө

## Ц.Цогзолмаа

мэдрэх, юмсын хэлбэр, дүрс, хэмжээ, багтаамж, хоорондын зай, харьцаа алс буй хол ойрын зай зэргийг танин мэдэх. (11 том. Из-во “БСЭ”.. М., 1952. стр. 475, Орч. Ц.Цогзолмаа.)

Хүн судлалд нүдний аньсга /нүдний хоорондох зай/, түүний налуу болон солонгон бүрхүүлийн өнгийг харгалзан үздэг. Монгол гаралтай хүмүүсийн нүдний аньсга нарийн анигар /жийтгар/ бөгөөд нүдний гадна булан нь доторхоосоо өндөр байдаг. Энэ нь эпикантус илүү хөнжсөнтэй холбоотой юм. Европ гаралтай хүмүүсийн нүдний аньсга нь хэвтээ ба дунд зэргийн өргөн байхад хар арьстангуудийнх – өргөн байдаг байна. Солонгон бүрхүүлийн өнгө нь нөсөөгийн тоо болон гүний байрлалаас шалтгааллах ба энэ нь нүдний өнгийг тодорхойлдог: хар /хар хүрэн, цайвар хүрэн, шар/, холимог /улаан-шар-ногоон, ногоон, саарал-ногоон, хүүхэн хараа тойруулаад шар цэцгийн туурцагтай саарал/, цайвар /саарал, саарал-цэнхэр, цэнхэр, хөх/. Хар нүд ихэвчлэн хар пигменттэй арьстангууд эзлэх бөгөөд европ арьстангууд – ихэнх хувь нь холимог ба цайвар нүдтэй. Солонгон бүрхүүлийн өнгө нь бэлгийн болон насны хувиралд ялимгүй өөрчлөгдөх бөгөөд сүүлийнх нь хувьд нөсөөжилт сулардаг.<sup>3</sup> (Орч. Ц.Ц.)

Харах эрхтэн нь нүдний алим /зөв бус бөмбөрцөг хэлбэртэй, усархаг шингэн, нүдний болор, шиллэг биеэс бүтнэ/, нүдний алимны бүрхүүл нь цагаан өнгөтэй, солонгон бүрхүүл, хүүхэн хараа, сормослог биеэс бүтнэ//, нүдний алимны туслах эрхтэн /аньсага, нулимсний аппарат, нүдний бүлчин, нүдний аяганы холбогч, харааны эрхгний судас, мэдрэлүүд/ гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Нүд гэрлийг мэдэрч, хүлээн авах үүрэг бүхий эрхтэн юм. Хүн нүдээрээ хардаггүй, тархиараа хардаг. Нүд бол зөвхөн харах гэж байгаа зүйлийг гэрлээр дамжуулж цуглуулж өгдөг үүрэгтэй. Аливаа зүйлийг хүлээн авч байгаа нь нүд, дамжуулж байгаа нь харааны зам буюу нүднээс тархи руу явдаг судас, хардаг хэсэг нь бага тархи юм. Харж байгаа бүх үйл явц бага тархинд явагдаж байдаг. Нүд болохгүй бол хүний толгой, мэдрэлд шууд нөлөөлж, зүгээр байвал тархи тайван байх нөхцөл бүрдэж байдаг. Гадаад орчинтой харьцаж байгаа мэдээллийн 80-90 хувийг өгдөг. Эндээс хэр чухал эрхтэн гэдэг нь харагдаж байна.<sup>4</sup>

Энэ монгол, орос хэлний тайлбар толь бичигт “харах эрхтэн” мөн нүд гэдэг үгтэй нийлэмж үүсгэдэг монгол, орос хэлний идэвхтэй нийлэмжүүдийг өгсөн бол монгол, орос хоёр нэвтэрхий толь бичигт нүдийг “хүн, амьтны харах эрхтэн”, “цэцгий, аньсага, нулимсний булчирхай” нүдний бүтэц, үүрэг талаас нь тодорхойлжээ.

Хүний биеийн эрүүл анатоми, Хүний физиологийн сурах бичигт Нүд нь бооронхий хэлбэртэй, нүдний аяганд байрлах нүдний алим, усархаг шингэн, болор, шиллэг бие, алимны бүрхүүл нь цагаан өнгөтэй, болор нь хар, алаг өнгөтэй, аньсага, сормуус, нулимсний аппараттай гэсэн тайлбар нь монгол, орос хэлний тайлбар, нэвтэрхий толь бичигт гэмдэглэгдээгүй байна.

Эдгээрт үндэслэн нүдний шинжийг тодорхойлъё.

НҮД:

*Үүрэг:* харах эрхтэн, гэрэл мэдрэх, өнгө мэдрэх, юмсын хэлбэр, дүрс, хэмжээ, багтаамж, хоорондын зай, харьцаа алс буй хол ойрын зай зэргийг танин мэдэх

*Бүтэц:* хос эрхтэн, нүдний алим /усархаг шингэн, нүдний болор, шиллэг биеэс бүтнэ/, нүдний алимны бүрхүүл нь цагаан өнгөтэй, сормуус, нүдний алимны туслах эрхтэн /аньсага, нулимсний аппарат, нүдний бүлчин, нүдний аяганы холбогч, харааны эрхтний судас, мэдрэлүүд/

*Хэлбэр:* зөв бус бөмбөрцөг хэлбэртэй

*Өнгө:* хар, хар хүрэн, цайвар хүрэн, шар

3. Большая советская энциклопедия. Л. А. Кацнельсон. [www.dic.academic.ru](http://www.dic.academic.ru)

4. Хүний биеийн эрүүл анатоми. ЭМШУИС. Био-Анигаахын сургууль. УБ. 2010. х.325-329



## Ц.Цогзолмаа

*Нүдний хөдөлгөөн*: аних, нээх, уйлах, өвдөх, торох, сэхэлзэх, тормолзох, мэлтрэх, сүүмийх.

Тайлбар болон нэвтэрхий толь, анатомийн сурах бичигтэй ажилласнаар бид нүдний шинж байдлыг шинжлэх ухаан талаас тодорхойллоо. Энэ мэдлэгийг оньсогонд туссан нүдний шинжтэй харьцуулахад хүний нүдний хэлбэр, өнгө, байрлал, хөдөлгөөн оньсогод тусаж далд зүйрлэл үүссэн байна.

Үүний дараа ажиглалтынхаа хоёрдахь хэсэгт анхаарлаа хандуулья.

Монголчууд нүдний гухай оньсогод нүдийг ямар шинжээр юутай холбон далд дүрслэл үүсгэдэг болохыг тогтоохын тулд бид эх сурвалжаас түүвэрлэсэн 103 оньсогыг дараах байдлаар ангилан үзэх боломжтой гэж үзэж байна:

№	Бодит ертөнцийн юм үзэгдэл	Тоо
1	Мал	21
2	Нүдний үйлдэл	14
3	Хүн	12
4	Нуур, далай, тэнгис	10
5	Шувуу	9
6	Эд хогшил	9
7	Уул, чулуу, тэнгэр, хад, булаг	7
8	Мод, өвс ногоо	6
9	Бурхан	4
10	Ан амьтан	3
11	Хоол хүнс	2
12	Нүдний өнгө, хэмжээ	2
13	Үс	2
14	Идээ	1
15	Үнэт чулуу	1

Эдгээр ангилал тус бүрийг тус бүрт нь авч үзье.

### 1. Мал

Монголчууд эрг үеэсээ нүүдэлчин удмаа хадгалж үлдсэн орчин үед ч хөдөөний малчин ард түмэн маань нүүдэлчин шинж чанараа гээгээгүй нүүдлийн мал аж ахуйгаа эрхлэн, малынхаа ашиг шимийг авч аж төрж ирсэн билээ. Монголчуудад мал, мал аж ахуй нь амьдралынх нь хамгийн чухал хэсгийн нэг байсаар ирсэн. Аж амьдралынхаа амин чухал хэрэглээгээ бүгдийг нь малын ашиг шимээр хангаж ирсэн монгол түмний ардын аман зохиол, утга зохиол яруу найрагт мал аж ахуйтай холбоотой үг хэллэг зүйрлэл, харьцуулал байх нь элбэг тохиолддог. Үүний нэг жишээ нь монгол ардын аман зохиолын нэг төрөл зүйл болох оньсого юм. Одоо тайлбарлах оньсогын энэ төрөлд хүний нүдийг мал аж ахуй, малтай холбож зүйрлэсэн зүйрлэл олон байна. Ялангуяа *бод мал буюу* *хэр, адуу, тэмээтэй* зүйрлэх нь *бог мал буюу хонь ямаатай* зүйрлэсэн зүйрлэлээсээ илт их байгаа нь ажиглагдаж байна. Дээрх оньсогуудаас харахад хүний нүдийг *малын алаг зүстэй* их зүйрлэсэн байна. Өдөр тутмын амьдрал нь малтай салшгүй холбоотой болохоор дан ганц оньсого ч гэлтгүй аливаа юмсыг зүйрлэх харьцуулахдаа малтайгаа харьцуулж зүйрлэх нь монголчуудад түгээмэл байдаг.

Малын зүс нь *алаг, хар бараан, цайвар өнгө* зүснээс бүрддэг бөгөөд хүний нүдний *хар, цагаан өнгийг* малынхаа алаг зүстэй зүйрлүүлэн *хар хэр, хар хонь, алаг тугал, алаг морь, алаг даага, хээр морь* гэх мэтээр илэрхийлсэн нь эдгээр оньсгуудад түлхүү ажиглагдаж байна.

Монгол түмэн малаа хариулаад орой үдэш нь аюулгүй байдлын үүднээс малаа ялангуяа

Ц.Цогзолмаа

бага залуу мал хашаанд хашдаг. Үүнтэй адил нүдний тухай оньсогоо ч аж амьдралынхаа энэ байдалдаа холбон нүдний 2 зовхи, сормуусыг хашаа, хороо, агуйтай зүйрлэсэн тохиолдол элбэг байна. Тухайлбал сормуусыг хялгасан хашаа, харгана хашаа, бургасан хашаа, хялгасан хороо гэх мэтээр зүйрлэн хэлсэн нь хашаа хороо нь гаднах байдлаасаа хэрхэн харагддаг, юутай зүйрлүүлж болох талаар илэрхийлсэн утга агуулгыг нь илтгэж байна. Мөн нүдний аягыг агуйтай зүйрлэж нүдний байнгын хөдөлгөөнтэй байдгийг нь тодруулах үүднээс малтай зүйрлэсэн нь хашаандаа байгаа мал сүрэгтэйгээ хүний нүдийг зүйрлэснийг нь нотолж байна.

\*\*\*\*

*Агуй дотор  
Алаг ямиа*

\*\*\*\*

*Бяцхан хашаанд  
Бөндгөр алаг тугал*

\*\*\*

*Алаг бяруу  
Хялгасан хороотой*

\*\*\*\*

*Бургасан хашаанд  
Боорлог тугал*

\*\*\*\*

*Алаг бяруу  
Аргалын хог даахгүй*

\*\*\*\*

*Тэнгэрээс ондөр  
Тэмээнээс намхан  
Хөөнөөс хар  
Ховонгөөс цагаахан*

\*\*\*\*

*Алаг морь  
Аргалын хог даахгүй*

\*\*\*\*

*Хар үхэр  
Харгана хашаатай*

\*\*\*\*

*Алаг тугал  
Хялгасан ногттой*

\*\*\*\*

*Хотон доторх  
Хар хонийг барьж болсонгүй*

\*\*\*\*

*Армиг тармаг модны цаана  
Алаг морьтой эргүүл явна*

\*\*\*\*

*Цагаадайн хүү нь харалдай  
Харалдайн хүү нь хар бух*

\*\*\*\*

*Дахгүй мөртоо  
Диардаггүй  
Давхидаггүй мөртоо  
Хурдан*

\*\*\*\*

*Эрэг дор  
Эрээн хуц*

\*\*\*\*

*Хар морь хантайрастай  
Хашу булга бөгтрөөтэй*

\*\*\*\*

*Хэцэд  
Хэдэн бараан адуу /хөмсөг/*

\*\*\*\*

*Хялгасан хороонд дотор  
Хилэн хар морь*

\*\*\*\*

*Хэц дээр хээр морь /хөмсөг/*

\*\*\*\*

*Алаг даага  
Хялгасан хашаатай*

\*\*\*\*

*Далайн зах дээр  
Даага шарвана /нүд цавчих/*

## Хүн

Хүний нүдний тухай оньсогыг өөрөө өөртөөгөө зүйрлэж олон янзаар илэрхийлсэн байна. Тухайлбал хос нүдийг *ах дүү, эгч дүүтэй* зүйрлэж хүний нүдний шинжээс аль нэгнээ хэзээ ч харж чадахгүй гэдгийг нь илэрхийлж цөөнгүй оньсого дээр *аль алинаа, бие биенээ, бараа бараагаа хараагүй* гэж хэлжээ. Нүдийг алс ойрын юмс үзэгдлийг харж тархинд мэдээлэл дамжуулдгийг нь *нэг уулын хоёр манаач* гэсэн зүйрлэлээс ойлгож болохоор байхад *нүдний аягыг гол устай* зүйрлэн түүн дотор хоёр хүүхэн умбан сэлж байгаагаар нүдийг хэлсэн нь бас л нүдний хөдөлгөөнийг усан дотор хүн сэлж буйтай зүйрлэн илэрхийлснийг илтгэж байна. Түүнчлэн *толгойг уултай, хамрыг гүвээтэй, нүдний аягыг гол морон, тэнгистэй* холбон зүйрлэн гаргаж байгаа нь монголчууд олон зуун жилийн турш мал аж ахуй эрхлэн байгаль, уул устайгаа ойр амьдарч ирсний нотолгоо болж түүнийгээ оньсого болон бусад ардын аман зохиолдоо дүрсэлсэн байдгийг эдгээр оньсогоос харж болно.

\*\*\*\*

*Эгч, дүү хоёр байж  
Аль алиныхаа барааг хараагүй*

\*\*\*\*

*Нэг уулын хоёр манаач  
Хоёр тагнуультай  
Гучин хоёр чонотой*

\*\*\*\*

*Эрхтийн гол дотор  
Ичимтгий хоёр хүүхэн умбана /хүүхэн  
хараа*

\*\*\*\*

*Байдгийг үздэг хоёр  
Бараа бараагаа үздэггүй хоёр*

\*\*\*\*

*Ихэр төрсөн  
Эгч дүү хоёр  
Өдий болтол*

*Аль алинаа үзээгүй*

\*\*\*\*

*Гүвээний хоёр талд  
Ах, дүү хоёр*

\*\*\*\*

*Хөх тэнгисийн хөвөөнөөс  
Хэлтэй цэрэг мордож*

*Горлосын хүүхэд /Өвөр Монголын нэгэн аймаг/*

*Гол хавчин цохилдоно*

## Нуур, далай, тэнгис

Нүдийг нуур, далайтай зүйрлэсэн зүйрлэл нь мал сүрэгтэй зүйрлэсэн зүйрлэлээс харьцангуй цөөн байгаа боловч утга агуулгын хувьд гүн гүнзгий хэн хүнд ойлгогдохоор дүрслэгдсэн байна. Тухайлбал хоёр нүдийг *хоёр нуур, холбоо нуур* гэх мэтээр зүйрлэж нууран дотор *нугас, даага* орж байгааг нүдэнд юм орохтой зүйрлэсэн байна. Түүнчлэн *нууран дотор орсон амьтан* зовохгүй байхад *нуур өөрөө зовно* гэсэн утга хэд хэдэн оньсого дээр илэрч байгаа нь *нүдэнд юм ороход нүд өвдохийг хэлжээ*. Нүдийг хүнтэй зүйрлэсэн оньсогоны хэсэг дээр *хамрыг даваа гүвээтэй, нүдийг агуйтай* зүйрлэж байсан бол энэ хэсэгт *хамрыг хондийн сонор байц* буюу *хондий хад, сормуусыг сэжүүр хад, гишүүгүй хулстай* зүйрлэжээ.

## Шувуу

Хүний нүдийг *шувуутай* зүйрлэсэн зүйрлэл ч цөөнгүй байгаа нь дээрх оньсого дээр харагдаж байна. Тухайлбал *шаазгай, галуу* зэрэг шувуугаар нүдийг зүйрлэн илэрхийлсэн нь *шаазгайн хар цагаан өнгөөр нүдний хар цагаан өнгийг* илэрхийлж байгааг оньсого таах гэж буй

## Ц.Цогзолмаа

хүнд ойлгуулахад дөхөм болох үүднээс зүйрлэсэн нь лавтай.

*Араг дотор гүдээсээр боож хийсэн сав  
Алаг шаазгай*

*Худаг дотор  
Хуурай галуу*

Нүдний сормуусыг ч энэ хэсэгт *арэг, шаазгайн сүүл* зэргээр далд утгаар илэрхийлж бөөр *алаг шувуу бүгд олонтой харьцана* гэсэн оньсогоор нүд бүх мэдээллийг авч байдгийг илэрхийлэн харуулжээ.

*Шар шаазгай  
Шагшиж чадахгүй  
Сайхан сүүлээ  
Шарван наадна*

*Сүрэг шаазгай  
Сүүлээрээ наадна*

\*\*\*\*

*Бөөр алаг шувуу  
Бүгд олонтой харилцана*

### Нүдний үйлдэл

Нүдний гүйцэтгэж буй үүрэг, нүдний өөрийн шинжийг өөр бусад зүйлтэй зүйрлэн хэлсэн оньсогууд энэ хэсэгт байна. Тухайлбал нүд харахад *алганд ч багадаа хар жижиж хэмжээтэй боловч асар холын тал шиг их зүйлийг харж чаддаг, маш их мэдээлэл нүдээр дамжин хүнд хүрч байдгийг илэрхийлсэн* оньсогууд энэ хэсэгт багтжээ. Мөн өдөр нь юм харж, шөнө нь аньж амардагийг хэлэхийн зэрэгцээ нүдний *аньсага, сормуусыг үст үүдтэй* зүйрлэн доторх нүдийг нь *үзэсгэлэнт хиатай* зүйрлэж оньсогогч таах гэж эн хүнд багагүй бодох урга ухааныг нь шавхах олон оньсого нүдтэй холбоотой эдгээр оньсогод байна.

*Атгахад атга дүүрэхгүй  
Тавихад тал дүүрнэ*

*Атгахад атгын чинээ  
Тавихад талын чинээ*

*Атгахад атгаар нэг  
Тавихад талаар нэг*

*Дэлгэвэл дэлхийн чинээ болдог  
Хумивал хуруун чинээ болдог*

*Өдөр нээлттэй  
Шөнө хаалттай*

*Үст үүд  
Буугаад ирлээ  
Үзэсгэлэн хиа нь  
Далдраад орлоо*

### Эд хогшил

Монголчууд аж амьдралдаа хэрэглэж ирсэн эд хогшил эрхэлж ирсэн мал аж ахуйгаа ардын аман зохиолдоо асар ихээр шингээснийг дээр дурдсан. Түүний адил хүний нүдийг илэрхийлсэн оньсогогч энэ хэсэгт эд хогшил аж амьдралдаа хэрэглэдэг ахуйн хэрэглэгдэхүүнүүдээ гүлхүү оруулж зүйрлэсэн оньсого байна. Тухайлбал *тогоо, сав суулга, гэр, халбага, тоглоом* зэрэгтэй зүйрлэсэн зүйрлэл цөөнгүй байгаа нь өдөр тутам байнга хэрэглэгддэг зүйлсээ оньсогод оруулан хүний оньсого таах, түүнийг зүйрлүүлэх олон шинж оруулан гаргаснаараа онцлог байна.



Ц.Цогзолмаа

*Дээд гэр идээтэй будаатай  
Дунд гэр хэрүүлтэй, маргаантай  
Доод гэр яриантай, хөөрөнтэй*

*Монгон халбага дотор  
Мөнхийн хар ус*

\*\*\*

*Ээжийн огсон хоёр савыг  
Одоо болтол хараагүй байна*

\*\*\*  
*Суулга дотор  
Суумал шил*

\*\*\*

*Тогоон дээр тоглоом наадам  
Эргэн дээр элээ наадам  
Дотор газар ноён наадам*

\*\*\*  
*Хажууд халбин тогоо*

**Уул, чулуу, тэнгэр, хад, булаг**

Хүний нүдийг хад, чулуу, тэнгэр, булагтай зүйрлэсэн зүйрлэл ч бас дээрх оньсогуудад илэрч байна. Тухайлбал *Молцог чулуу мориноос хурдан* гэдэг оньсого дээр *нүдийг молцог чулуутай* зүйрлэн мориноос хурдан гэдэг нь *их холын юмыг олж харах нь морины хурдаас ч илүү хурдан* гэдгийг илэрхийлсэн байх жишээтэй.

*Тэнгэрийн нар жаргав*

*Түмэн хялгас нийлэв*

*Огторгуйн нар оров*

*Олон хялгас нийтэв.* Энэ оньсогод хүн унгаж амрахыг, нүдээ анихыг илэрхийлсэн бол

*Босоо хадны өмнө*

*Бумбагар хоёр нуур бий*

*Бусад нууртай таарахгүй нуур*

*Бүзар бүртгийг оруулахгүй нуур* гэсэн оньсогод хүн нүдээ хайрлаж нүдэндээ юм оруулахгүй, өвдүүлэхгүйг хичээдгийг илэрхийлсэн байна.

**Мод, бургас, өвс, хулс**

Нүдний сормуусыг *мод, бургас, өвс, хулстай* зүйрлэх нь хүний нүдтэй холбоотой оньсогод элбэг байна. Учир нь нүдний сормуусыг байгаль орчинд харагдаж байгаа юмс үзэгдлээс юутай нь зүйрлэж болох талаар бодож тунгаасан ард түмний зөв оноож зүйрлэсэн зүйрлэл гэж хэлж болохоор байна.

*Бургасыг  
Бургасаар ороолгоно*

*Гялгар нуурын хөвөөнд  
Гилжгэр өвс ургих*

\*\*\*

\*\*\*\*

*Богцны амсарт  
Бор бургас*

*Төгрөг нуурын хөвөөнд  
Төгөл хулс ургажээ /тростник/*

\*\*\*

\*\*\*\*

*Далайн захид  
Зулзаган модод /залуу мод/*

*Эргэн дээр  
Эмжээр өвс  
Наад голын нарс  
Цаад голын царс  
Нар шингэхийн үеэ  
Намаагаараа нийлнэ*

## Ц.Цогзолмаа

### Бурхан

Монгол хүн бие эрхтэн дотроосоо энхрийлэн хайрлаж амин чухал эрхтэнүүдийнхээ нэгийг нүдээ гэж үздэг. Тиймээс аливаа зүйлийг хайрлаж хамгаалах энхрийлэхээ нүдний цогцийг мэт хайрлая гэж хэлэлцдэг. Тиймээс нүдээ эрхэмлэн дээдэлдэг *бурхан шүтээн*тэйгээ жишин холбон илэрхийлсэн нь ажиглагдаж байна.

*Суулган дотор  
Суумал бурхан*

\*\*\*\*

*Хөвөнд боосон  
Хоорхон бурхан  
Цэмбэнд боосон  
Цэвэрхэн бурхан*

*Бурхнаа  
Бургасаар гуяданаа*

\*\*\*\*

*Агуйд алаг бурхан  
Шугуйд суумал бурхан*

### Ан амьтан

Хүний нүдийг чоно, луу, хэрэм зэргийн ан амьтангай зүйрлэж нүдний өнгийг чонын онготой, нүдний аягыг агуйтай, нүдний оч, сормуусыг луу, хэрэмний сүүлтэй зүйрлэжээ.

*Агуйд  
Алаг чоно*

\*\*\*\*\*

*Хэрэд  
хэрмэн сүүл /хөмсөг/*

*Хэрмийн дээр  
Хэвтээ луу*

### Хоол, хүнс

Хоол хүнс агуулсан нүдний оньсогыг нүдний хэлбэр, өнгө, байрлалаар хүн өөрийн хэргэлдэг хоол хүнстэйгээ шүүд шижээд нүдний аягыг - цай, хоолны аягаар харин нүдний алимыг - алаг мах, алаг өндөгөөр зүйрлэжээ.

*Аяган дотор  
Алаг өндөг*

*Аягаар дүүрэн  
Алаг мах*

### Хорхой

Дараах оньсогод нүдний өнгө, бүтцээс хамаараад нүдийг *алаг хорхоо, хар цох хорхоотой*, нүдний аягыг *авдар, харш ордонтой* зүйрлэжээ.

*Авдар дотор  
Алаг хорхой*

*Харш дотор  
Хар цох*

### Нүдний өнгө, хэмжээ

Хүний нүдийг бүтцийг дүрслэн хэлэхдээ монголчуудын ихэнхи нь алаг, бор, хар нүдтэй байдгийг анзааран болорыг /хүүхэн хараа/– дугуй хар, нүд нулимсаар дүүрэхэд – мэлтэн *хар*,

## Ц.Цогзолмаа

сормуусыг – *хялгастай* мөн нүд нь халуун, хүйтнийг мэдрэхгүй тул хүйтэнд хөрөхгүй, халуунд халахгүй гээд нүдийг хүйхэртэй адилтгажээ.

*Үзүүртээ үстэй*

*Хязгаартаа хялгастай*

*Дундаа дугуй хар*

*Тусах /дусаал/ нь мэлтэн хар*

*Хүйтэнд хөрөхгүй хүйхэр*

*Халуунд халахгүй хүйхэр*

### Үнэт чулуу

Нүд – хүний хамгийн нандин эрхтэн ямар ч юмнаас үнэтэй зүйл тул монголчууд үнэт чулуу болор эрдэнтэй харьцуулан хүний биед ямар чухал үүрэг гүйцэтгийг харуулжээ.

*Бүгдээс үнэтэй*

*Болор эрдэнэ*

### Идээ

Дараах оньсогод хүний нүдийг “Идээ” – идээний дээжтэй зүйрлэжээ. Идээ гэдэг үг өөрөө бие даасан 4 утгагай байна.

1-р утга: идээний дээж, цайны дээж, жимсний зөөлөн хэсэг, идээ хавчсан

2-р утга: цөм

3-р утга: идээ сайн орсон арьс элдэхэд хялбар

4-р утга: идээ бээр, идээ татах, суух, идээ шахах, идээ ялгадас.<sup>5</sup>

Ямарч байсан нүдний аягыг – завагаар /зав гэдэг үг нь бие даасан 3 утгатай бөгөөд – 1-р утга: амрах зав, амсхийх зав, зав чөлөө, 2-р утга: шель, жерло, скважина, узкая долина, теснина, ложбина, овраг, уулын зав горная ложбина, 3-р утга – за-гаар эхэлсэн үгэнд хүч нэмэгдүүлэх сул үг/, харин нүдний бүрхүүл, болорыг – заваахан /заваан/ - 4 бие даасан, 1 шилжсэн утгатай үг /1-р утга - давсгүй, 2-р - амтгүй 3-р – постный, шилжсэн утга – заваан, бохир гэсэн утгатай/ идээ гэжээ. Заваахан идээ гэдэг нь заваан гэсэн үг нь шууд утгаараа бус шилжсэн утгаараа энэхүү оньсогод хэрэглэгдсэн байна..

*Завагт*

*Заваахан идээ*

### Үс

Хүний нүдний нэгээхэн хэсэг болох сормуусыг хүн *үстэй* зүйрлэжээ. *Үс үсээрээ нийлтэ* – энэ оньсогод хүн унтахад нүдээ аниж унтахад дээд, доод сормуус нийлж байгааг ийм байдлаар дүрсэлжээ. Дараагийн оньсогод

*Хавчиг зууван биетэй*

*Хажуугаараа үстэй* гэдэг нь нүдний алимыг хэлбэрийн хувьд хавчгар хоёр этгээдээс шахагдсан мэт хэлбэртэй /зөв биш бөөрөнхий, зуйван хэлбэртэйг нь/, нүдний сормуусыг – үстэй харьцуулсан байна.

5. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Д-О. Ред. Л.Болд. УБ. ШУА. 2008. х. 1412-1414

***Нүдний шил***

Нүдний шил – хүн төрөлхтөнтэй олон мянган жил хамт явж маш чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Хүний нүдний хараа нас ахих тусам мууддагийг шинжлэх ухаан аль хэдийнээ баталсан. Харин нүдний шил хүнд харах боломжгүйг боломжтой болгож хүнд баяр баясгалан авчирдаг:

*Хамар дээр сандайлж суугаад*

*Чихэн дээгүүр хөлөө жийнэ* гэсэн оньсогонд нүдний шилний эх биеийг хүний хамар дээр байрлахыг хүн юман дээр хоёр хөлөө унжуулан сууж байгаа мэт *сандайлж суугаад* гэсэн бол хүн амьтны атирсан, нугалсан хөлөө тэнийлгэх, сунгахыг нүдний шилний гуятай зүйрлэжээ.

**ДҮГНЭЛТ**

Эх сурвалжаас түүвэрлэн авсан хүний нүдтэй холбоотой 103 оньсогыг ангилж судлахад монгол ард түмэн оньсого зохиохдоо нүдийг мал, хүн, нуур, тэнгис далай, шувуу, эд хогшил, уул, чулуу, тэнгэр, хад, булаг, мод, өвс ногоо, бурхан, ан амьтан, хоол хүнс, үс, идээ, үнэт чулуутай холбон далд зүйрлэл зохиохоос гадна нүдний харах үйлдэл, харааны чадвар, харагдах шинж байдлыг харгалзан оньсого зохиодог болохыг бид тогтоолоо. Эдгээрээс харахад ард түмэн оньсого зохиохдоо оюуны нарийн үйлдэл хийж өөрийн танин мэдэх сэтгэлгээний түүхт хөгжлийн үр дүнг тусган гүн, дэлгэр агуулгагай, гайхам уран яруу ёгт хэлбэртэй асуудалт асуулт буюу оньсого зохиодог нь илт байна.



Ц.Цогзолмаа

## НОМЗҮЙ

### Толь бичиг

- Большая советская энциклопедия. 11 том. М., Из-во "БСЭ". 1952 г. стр.472-475  
Малый академический словарь. [www.dic.academic.ru](http://www.dic.academic.ru)  
Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. М-С. Ред. Л.Болд. УБ. ШУА. 2008.х. 1412-1414  
Монгол хэлний товч тайлбар толь. Я.Цэвэл. УХХЭХ. УБ. 1966. х. 391-392  
Монголын нэвтэрхий толь. УБ. ШУА. 2000. х.647  
Советский энциклопедический словарь. М., Из-во "Сов. Энци.", 1985г. стр.310

### Ном, сурах бичиг, өгүүлэл

- Хүний биеийн эрүүл анатоми. ЭМШУИС. Био-Анагаахын сургууль. УБ. 2010. х. 325-329  
Хүний физиологи. ЭМШУИС. УБ. 2003. х. 273-277  
Базардорж П. Оньсого гааврын учир. Шинжлэх ухаан. амьдрал сэтгүүл. 1966. УБ. х.30-31  
Будрагчаа Д. Аман зохиолын дээжис. Монгол ардын оньсого. Соёмбо принтинг.УБ. 2008. х.48-49  
Гаадамба Ш., Цэрэнсодном Д. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. УХГ. 1978. Х. 35-36  
Далайжамц Ё. Ардын аман зохиолын цуврал. Оньсого I. УБ. х. 40-41  
Ловор Г. Монгол оньсогын уран сайхны онцлог, утга, учир зүй. УБ. 2005  
Ловор Г., Ц.Өлзийхутаг. Монгол ардын оньсого таавар. УХГ. УБ. 1990. х. 136-139  
Өлзийхутаг Ц. Түмэн оньсого. 1-р боть. ШУАХЗХ, УБ. 1966. Х. 133-135  
Өлзийхутаг Ц. Түмэн оньсого. 2-р боть. ШУАХЗХ. УБ. 1989. х.108-110  
Цогзолмаа Ц. Оньсого ард түмний танихуйн товч хураангуй болох нь /монгол. орос хэлний жишээн дээр/. ГХСС, ЭШБ. боть 363 /16/, х.93-100  
[www.dic.academic.ru](http://www.dic.academic.ru)  
[www.excimerclinic.ru](http://www.excimerclinic.ru)